


МОНГОЛ УЛС. ЗАВХАН АЙМАГ

АЙМАГ БОЛОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД “БИЕ ДААН” НЭР ДЭВШИГЧ
БААТАРЫН БАТДЭЛГЭРИЙН 4 ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2020.07.23

**АЙМАГ БОЛОН СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД “БИЕ ДААН” НЭР ДЭВШИГЧ
БААТАРЫН БАТДЭЛГЭРИЙН ДЭВШҮҮЛЖ БҮЙ “НУТГАА ХӨГЖҮҮЛЬЕ,
ЭХЛҮҮЛСНЭЭ ҮРГЭЛЖҮҮЛЬЕ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нээлттэй тогтолцоог бүрдүүлж нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа хамтын ажиллагааг өргөжүүлэх бүтээлч арга хэмжээ зохион байгуулна.

2. Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн саналд тулгуурлан шийдвэр гаргах зорилгоор Аймгаас уламжлал болгон зохион байгуулдаг “Ард иргэдээ сонсох аян”, төрийн үйлчилгээг ард иргэдэд ойртуулах зорилгоор Төрийн цогц үйлчилгээг багт зэрэг арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3. Аймгаас зохион байгуулах Төрийн албан хаагчийн сурч боловсрох, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн мэргэшсэн тогтвортой байх тогтолцоог бүрдүүлнэ.

ХОЁР.НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Аймгаас зохион байгуулах Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон болон олон хүүхэдтэй эрхэлсэн тодорхой ажилгүй идэр насны эрэгтэйчүүдэд зориулсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тусгайлсан хөтөлбөрийг баг бүрт хэрэгжүүлж, ажлын байр, хувийн өмчтэй болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн эмзэг бүлэг, өрх толгойлсон иргэдийг нийгмийн хамгааллын хуулийн дагуух тэтгэмж, тусламж дэмжлэгт жигд хамруулж ажиллана.

3. Спорт цогцолбор, Хөл бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын газрыг шинээр байгуулна.

4. Соёл амралтын хүрээлэн байгуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

5. Армийн генерал Батын Доржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн байршилыг өөрчилж шинэчилэн засаж байгуулна.

**ГУРАВ. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

1.Ноос, ноолуур угаах, самнах, арьс шир боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулна.

2. Дайвар бүтээгдэхүүний үйлдвэр байгуулна.

3. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.

4. Одоо ажиллаж байгаа Сүлжмэлийн үйлдвэрийг өргөжүүлнэ.

5. Хүнсний бүтээгдэхүүн зарж борлуулдаг Супермаркет шинээр байгуулна.

6. Халуун ус, үсчин гоо сайхан, фото зурагчин, нотариат, компьютер ба гар утас, цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, нарийн боовны цех, оёдол хувцас захиалга, гутал засвар, Автомашины дугуй болон машин засвар, гагнуур зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний төвийг бий болгоно.

5.Хүнсний бүтээгдэхүүн зарж борлуулдаг Супермаркет шинээр байгуулна.

6.Халуун ус, үсчин гоо сайхан, фото зурагчин, нотариат, компьютер ба гар утас, цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, нарийн боовны цех, оёдол хувцас захиалга, гутал засвар, Автомашины дугуй болон машин засвар, гагнуур зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний төвийг бий болгоно.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж Фермерийн аж ахуй байгуулах, хуурай сүү боловсруулах, цөцгийн тос үйлдвэрлэх, мах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.ХАА-н техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх боломжийг судалж үе шаттайгаар хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг найдвартай машин механизмаар хангана.

3.Малын үүлдэр угсааг сайжруулах, сүргийн бүтцийг зохистой хэмжээнд барихад малчдад дэмжлэг үзүүлнэ.

4.Малын халдварт өвчинтэй тэмцэж, малын үзлэг, тарилга туулгын чанарыг сайжруулж, мал сүргийг эрүүлжүүлэхэд эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

5.Малчдын амьжиргааг дээшлүүлэх мал аж ахуйн салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлэх "Сайн малчин" хөтөлбөр, залуу малчин өрхийг дэмжсэн "Малжуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

6.Нутгийн хөрсөнд ургасан чанартай хүнсний ногоогоор, хүн амыг жилийн туршид хангах зорилгоор Сумын төв болон Улиастай сумд хүнсний ногооны төвлөрсөн зоорь барина. Мөн хүлэмжийн тариалалтыг дэмжин, нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

7.Улаан хальст сармисны тариалалт борлуулалтыг дэмжиж дэмжлэг үзүүлнэ.

ТАВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.Доной аялал жуулчлалын мэдээллийн төвийг ашиглалтад оруулж Хар нуур үндэсний парк хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.Байгаль орчин, ялангуяа голын ай сав, булаг шанд, ой модыг хайрлан хамгаалах, нөхөн сэргээх, арчилж цэвэрлэх талаархи сургалт сурталчилгааны компанит ажлыг үе шаттайгаар тогтмол явуулж, ой мод, гол горхи, булаг шандыг хамгаалах аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг тууштай дэмжинэ.

3.Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиглэлээр хүүхэд залууст зориулсан эко боловсролын тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, тэдгээрийн байгаль хамгаалах санал санаачилга, сайн дурын хөдөлгөөнийг урамшуулан идэвхижүүлнэ.

4. Сумын хогийн цэгийг өөр газарт байршуулж хуучин хогийн цэгийг дарж булах ажлыг зохион байгуулна.

5. Сумын төвийн шинэчлэлийн хүрээнд Цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

6. Армийн генерал Б.Доржийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдын ногоон төгөл шинээр байгуулна.

7. Жуулчны бааз, жуулчны гэр хотхоны үйл ажиллагааг дэмжин, оюутан залуусыг хөтчөөр ажиллуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

8. Уул уурхайн лиценз олгохгүй, уул уурхайгүй сум болно.

ЗУРГАА. СОЁЛ, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг нэмэгдүүлэх зорилгоор спортын олон төрлийн уралдаан тэмцээн явуулах боломжтой орчин үеийн цогц үйлчилгээтэй Спортын ордон барьж байгуулна.

2. Үндэсний бөх, морь, сур, шагайн харвааны спортыг тууштай хөгжүүлж, бүх төрлийн дэмжлэг үзүүлнэ.

3. Хүүхэд залуучуудын спорт урлагийн наадмыг олон төрлөөр тогтмол зохион байгуулж, тэдний авъяас чадварыг хөгжүүлнэ.

ДОЛОО. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Сумын эмнэлэгийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт суурилсан санхүүжилтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, боловсронгуй болгоно.

2. Эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг хурдан шуурхай, хүртээмжтэй болгож, техник тоног төхөөрөмжөөр ханган, явуулын эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

3. Сумын эмнэлгэд ажиллаж байгаа эмч, сувилагч, нарийн мэргэжлийн эмч нарын хүрэлцээг нэмэгдүүлж, тэднийг дотоод гадаадын мэргэших сургалтанд хамруулж, мэдлэг мэргэшлийг тогтмол дээшлүүлэх арга хэмжээ авна.

4. Рашаан сувиллын үйл ажиллагааг дэмжиж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

5. Хүүхэд, гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчин эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, ажлын байр, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгож, "Эрүүл мэндийг дээдлэгч байгууллага" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6. Сайн эмч хөтөлбөрийн үр дүн сайжруулах, эрүүл мэндийн салбар ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

НАЙМ. БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1.Багшлах боловсон хүчний ур чадвар, бүтээмж, ажлын гүйцэтгэл дээр суурилсан цалин, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх замаар багшийн ажлыг шударгаар үнэлж, мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өсгөн, цалингаараа хангалуун амьдрах, орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилготой Аймгаас зохион байгуулах "Сайн Багш", "Сайн Оюутан" хөтөлбөрийг хэрэгжүүлж, багшлах боловсон хүчнийг чадваржуулах арга хэмжээг авч ажиллана.

2.Сургуулийн өмнөх боловсролд зориулсан нүүдлийн цэцэрлэгийн баг бүрт гэр цэцэрлэгийг байгуулах ажлыг зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын сургалтыг нэмэгдүүлнэ.

3.Сургууль, цэцэрлэгүүд өөрийн хэрэгцээг хангах туслах аж ахуйг эрхлэх боломжийг дэмжинэ.

ЕС. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1.Шинэ сум төслийн хүрээнд сумын Залуу гэр бүл, төрийн албан хаагчдийг орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.Сумын төвийн айл өрх, аж ахуйн нэгжийг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай зохион байгуулж сумандаа сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

3.Гэр хорооллыг цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлнэ.

5.Богдын гол багийн нутаг дэвсгэр дэх Хүүхдийн Даян зуслангийн арын гүүрийг засварлана.


6.Сумын төвийн доторхи хатуу хучилттай замыг бүрэн хийж дуусгана.

7.Богдын гол багийн нутагт үүрэн телефоны станц шинээр байгуулна.

8.Сумын Сургууль, ЗДТГ-ын байранд засвар үйлчилгээ хийж, шинэчлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

9.Гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийг судалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

10.Шинэ сум төслийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.



----- ○ -----